



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ГУРВАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 27 өдөр

Дугаар 79

Пионер толгой

Техникийн хяналтын үзлэг, тээврийн  
хэрэгслийн албан татвар хураалтын ажлыг  
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Авто тээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 7 дугаар зүйлийн 7.1, 7.2 дахь заалт, аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн A/173 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 2022 оны тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, албан татвар хураалтын ажлыг зохион байгуулах комиссыг хавсралтаар баталсугай.

2. Техникийн хяналтын үзлэгийн үйл ажиллагааг жилийн турш, холбогдох стандартын шаардлага хангасны үндсэн дээр чанартай зохион байгуулж сумын Татвар хураагч, багийн Засаг дарга нартай хамтарч ажиллахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

3. Албан байгууллага, иргэдийн болон нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн байгууллагуудын тээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэг, албан татвар төлөлтөд бүрэн хамруулахыг багийн Засаг дарга нарт даалгасугай.

4. Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан байдал, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, орон нутгийн авто зам ашигласны төлбөр төлөлт, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд даатгагдсан байдалд бүтэн жилийн турш хяналт шалгалтыг тасралтгүй хийж, зөрчлийг тухай бүр арилгуулахыг Цагдаагийн хэсэгт үүрэг болгосугай.

5. Техникийн хяналтын үзлэг, албан татвар хураалтын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Э.Сүглэгмаа)-д үүрэг болгосугай.

ДАРГА Б.ГАНТУЛГА

640101263

Сумын Засаг даргын ...-ны  
05 сарын 27-ны өдрийн ...  
дугаар захирамжийн хавсралт

ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГ ЯВУУЛАХ  
СУМЫН КОМИСС

- Комиссын дарга: Э.Сүглэгмаа (Засаг даргын орлогч)  
Гишүүд Д.Азбаяр (Экологийн асуудал хариуцсан байцаагч)  
М.Саруулбуян (Татвар хураагч)  
Б.Лувсаншийрэв (Цэнгэл 1 дүгээр багийн Засаг дарга)  
Д.Мөнхчулуун (Давааны ам 2 дугаар багийн засаг дарга)  
Д.Болд-Аюуш (Буга 3 дугаар багийн Засаг дарга)  
Б.Баттулга (Хөвийн ам 4 дүгээр багийн засаг дарга)  
Ч.Батцэцэг (Пионер толгой 5 дугаар багийн Засаг дарга)  
Б.Сүмбэрзул (Олон нийтийн цагдаа)
- Нарийн бичгийн дарга: А.Бямба-Очир (хэсгийн цагдаа)

ооо